



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны ээлжит 05 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 05 дугаар хуралдаан 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар /2026-03-26/ Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийн тухай (Хорооны 2026 оны 14 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2025 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтийн тайлан”-гийн талаар танилцуулга; ХХЗХ-ны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулга (2025 оны жилийн эцсийн байдлаар); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл сэргээх, зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг тус тус хэлэлцээд, Зохицуулах хорооны 7 (Тогтоол №41-47, 2026-03-26) тогтоолыг батлан шийдвэрлэв.

Энэхүү хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулга (2025 оны жилийн эцсийн байдлаар), цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэв. Тус хуралдаанд Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8.9.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 дахь хэсэг болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд “ХХЗХ-ны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлан”-гийн дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулгыг авч хэлэлцээд, Зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга толилуулсан тухай “Өөрчлөлтгүй санал дүгнэлт” гаргасан Аудитын тайлан дахь аудиторын өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг хангуулах талаар цаашид төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж ажиллахыг Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/, Санхүүгийн алба /Н.Халиунаа/-д тус тус үүрэг болгов. Хорооны хуралдааны явцад Хорооны дарга, гишүүд зохицуулах хорооны 2025 оны санхүү, эдийн засгийн гол үзүүлэлт сайжирсан, орлого бүрдүүлэлт, төсвийн гүйцэтгэл зардлын хяналт, зарцуулалтын чиглэлээр хүрсэн үр дүнгийн талаар танилцуулж, Хорооны 2025 оны тайлант хугацаанд байгууллагын орлогын төлөвлөгөөг 186.6 хувиар давуулан биелүүлсэн; төсвийн гүйцэтгэлд 18.31 хувийн хэмнэлт гаргасан талаар Хорооны хуралдаанд мэдээлэв.

Тус хорооны 2026 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар /2026-01-30/ Хорооны 2026 оны 14 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” (Өмнөговь аймгийн Цогт-Цэций, Ханбогд сумын нутаг дэвсгэрт ХӨНС-д ашиглах радио давтамж, РД-ийн зурвас ашиглах багц сонгон шалгаруулалт зарлах тухай) тогтоолыг баталсан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-2026 /ӨГЦЦХБ-СШ-01/ тоот сонгон шалгаруулалтыг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл зарласан болно. Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар дээрх сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Үнэлгээний ажлын хэсгийн “ХХЗХ-2026 /ӨГЦЦХБ-СШ-01/ тоот сонгон шалгаруулалт”-ын үйл ажиллагаа, үнэлгээ гүйцэтгэсэн тайлан тэмдэглэл, холбогдох танилцуулга, үнэлгээний ажлын хэсгийн санал дүгнэлт болон “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолын төслийг тус тус авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4, 11.7 дахь хэсэг, Зохицуулах хорооны даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 41 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлан шийдвэрлэсэн. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Эм жи эл радио ньюс ХХК-ийг “Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай. Энэхүү тогтоолын 2 дугаар заалтад, Эм жи эл радио ньюс ХХК-д Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад 88.3 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2031 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай. Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Энэхүү тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл сэргээх, зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 42 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг (Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 43 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Жи Жи грийн ХХК Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –БНСУ/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 44 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөлд (Мобиком корпораци ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт үүрэн холбооны 4G технологид “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” (Ашиглах давтамж: 890-895МГц/935-940МГц, 897.5-902.5МГц/942.5-947.5МГц) 24310017 тоот тусгай зөвшөөрөлд “Ашиглах давтамж: 890-900МГц/935-945МГц” болгон) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 45 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Өв арвайн ундарга ХХК: “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100740 тоот тусгай зөвшөөрлийг) сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Төгс хурц консалтинг ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 46 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Төгс хурц консалтинг ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100481 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 03 дугаар 26-ны өдрийн 47 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 харилцаа холбооны сүлжээний дугаарыг (Өмгөөллийн поларис лав ХХК: 1-900-1959, Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ: 12-00, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: 11-09) 2 жилийн хугацаагаар олгож тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2026-04-02